ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

# Эм хангамжийн газрын 2022 оны гүйцэтгэлийн тайлан


Г.Цэцэнсанаа

Эм хангамжийн газрын дарга


2022.12.22

# Чиг үүрэг

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР




*Эрүүл мэндийн сайдын*
*2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн*
*А/23 дугаар тушаал*

1. Хүн ам, ЭМБ-ыг ЗШЭ-ээр тасралтгүй хүртээмжтэй хангах үйл ажиллагааг зохицуулах
2. ЗШЭ-ийн үнийн хяналт, зохицуулалт
3. Эмийн үнийн тандалт судалгаа
4. Эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авалтын үйл ажиллагааг зохицуулах
5. Эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийн байдалд судалгаа хийх
6. Гамшиг, онцгой байдлын үед эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдүүлэх үйл ажиллагааны зохицуулалт
7. Өнчин эмийн жагсаалтыг боловсруулж, шинэчлэх,
8. Эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийн нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх

# Хүний нөөц



**Эм хангамжийн газар (8 орон тоо)**

1. **Г.Цэцэнсанаа**
   Дарга

5. Эмнэлгийн хэрэгслийн үнийн зохицуулалт, өртөг үр дүнгийн судалгааны асуудал хариуцсан мэргэжилтэн

2. Эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж, хүртээмж, ложистикийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн

6. **Э.Мядагмаа**
   Эмийн үнийн зохицуулалт, өртөг үр дүн, эдийн засгийн судалгааны асуудал хариуцсан мэргэжилтэн

3. **Г.Хулан**
   Эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан мэргэжилтэн

7. **Н.Мөнхзаяа**
   Вакцин, биобэлдмэлийн хангамж, хүртээмж, ложистикийн асуудал хариуцсан мэргэжилтэн

4. Эм, эмнэлгийн хэрэгслийн үнэ, худалдан авах ажиллагааны мэдээний сангийн асуудал хариуцсан мэргэжилтэн

8. **Д.Оюун-Эрдэнэ**
   Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж, зохицуулалтын асуудал хариуцсан мэргэжилтэн

# 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө



1. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох — *2 ажил*
2. Эмийн худалдан авах үйл ажиллагаа, хангамж хүртээмжийг сайжруулах — *11 ажил*
3. Эм, эмнэлгийн хэрэгслийн үнийн зохицуулалт, өртөг үр дүнгийн тооцоо судалгаа — *4 ажил*
4. КОВИД 19-ийн цар тахал болон гамшгийн үеийн бэлэн байдлыг хангах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ — *5 ажил*
5. Бусад — *2 ажил*

Нийт 24 ажил



# 1. Хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр

# Хэрэгжүүлсэн ажлууд

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

“Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль” -ийг шинэчлэн найруулах ажлын хэсгийг мэдээллээр хангаж, хамтран ажиллана.

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан **“Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”**-ын дагуу “Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль”-ийн

- эмийн үнийн зохицуулалт,
- эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах

эрх зүйн зохицуулалтад үнэлгээ хийсэн.

✓ Эмийн үнийн зохицуулалтын чиглэлээр 3,
✓ Худалдан авах чиглэлээр 4 санал хүргүүлсэн.

Эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүний үнийн тандалт, зохицуулалт хийх журмыг шинээр боловсруулна.

- Казахстан улсын эмийн үнийн журмыг жишиг болгон МУ-ын эмийн үнийн зохицуулалтын журмын төслийг эхний байдлаар боловсруулсан.
- Эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүний үнийн тандалт, зохицуулалт хийх журмын төсөл боловсруулах ажлын хэсгийг ЭЭХХЗГ-ын даргын 2022.11.11-ний өдрийн А/212 дугаар тушаалаар ажлын хэсгийг байгуулсан.
- Ажлын хэсгийн 4 гишүүдээс ирсэн саналыг нэгтгэн төслийг шинэчлэн боловсруулсан.




# 2. Эмийн худалдан авах үйл ажиллагаа, хангамж, хүртээмжийг сайжруулах чиглэлээр

# Худалдан авалт, ерөнхий гэрээ

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

## ЕРӨНХИЙ ГЭРЭЭ

2021 онд

**83**

нэрийн эм, эмнэлгийн хэрэгсэл

ЦАХИМ ДЭЛГҮҮР

2022 онд

**116**

нэрийн эм, эмнэлгийн хэрэгсэл

2021-2022 он

22,7 тэрбум төгрөгийн хэмнэлт

Ерөнхий гэрээгээр худалдан авах эм, эмнэлгийн хэрэгслийг 2022 онд **38** нэрээр нэмэгдүүлж, цахим дэлгүүрээс тус онд 147 төрийн өмчийн байгууллага 116 эм, эмнэлгийн хэрэгслийн нийт **38,4** тэрбум төгрөгийн захиалга хийж, улсын төсөвт **9,9** тэрбум төгрөгийн хэмнэлт үүсгэсэн.

*Жишээ нь: Ремдесивир эмийн тендерийн үнэ 99,990₮ - 125,950₮ байснаас ерөнхий гэрээгээр худалдан авснаар 30,000₮ - 35,000₮ болсон.*

## ХУДАЛДАН АВАЛТЫН ҮНЭЛГЭЭ, МЭДЭЭНИЙ САН

### 2019-2021 он

Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагуудын худалдан авалтын мэдээний сан үүссэн

### Үнэлгээ

Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагуудын 2019-2021 онд худалдан авсан 12 нэрийн эм, 2 нэрийн эмнэлгийн хэрэгслийн хэрэглээ, дундаж үнэ, үнийн дүнд үнэлгээ хийсэн


ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР
World Health Organization
Representative Office for Mongolia

ТӨРИЙН ӨМЧИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХУДАЛДАН АВСАН ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ

(ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН)

### Сургалт, гарын авлага

Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагуудын 57 эм зүйчдэд "Цахим дэлгүүрээс эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах" сургалт зохион байгуулж, гарын авлага боловсруулсан


World Health Organization
Representative Office for Mongolia

"ЦАХИМ ДЭЛГҮҮРЭЭС ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ ХУДАЛДАН АВАХ"
ХЭРЭГЛЭГЧИЙН ГАРЫН АВЛАГА
ЗАХИАЛАГЧ БАЙГУУЛЛАГА

### Орон нутгийн ХА

Завхан аймгийн ЭМГ, НЭ, Орон нутгийн өмчийн газрын эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авалтад үнэлгээ хийсэн


ЗАВХАН АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР, НЭГДСЭН ЭМНЭЛЭГ, ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАРТ АЖИЛЛАСАН ТАЙЛАН

**Үндэслэл:**

Үндэсний статистикийн хорооны 2020 оны мэдээллээр Завхан аймгийн хүний хөгжлийн индекс 0.71 буюу улсын дунджаас 0.06 функцээр бага. Ядуурлын үндэсний түвшнээс доогуур амьжиргаатай хүн амын эзлэх хувь 25.7%, нэг хүнд ногдох орлогын хэмжээ 2,054 ам.доллар байгаа нь улсын дунджаас 46.6 хувиар доогуур, тогтвортой хөгжлийн зорилтоос 4.3 дахин бага үзүүлэлттэй байна. Иймд Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын санхүүжилтээр хэрэгжүүлж буй "Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагуудын худалдан авах ажиллагаанд үнэлгээ хийж, оролцогч талуудыг чадавхжуулах үйл ажиллагаа"-ны хүрээнд тус аймгийг сонгож, Төрийн худалдан авах ажиллагааны газартай хамтран Завхан аймгийн эм, эмнэлгийн хэрэгслийн сүүлийн 3 жилийн хугацааны (2019, 2020, 2021 он) худалдан авах ажиллагаанд үнэлгээ хийж, зөвлөмж өгч, чадавхжуулах зорилгоор томилолтоор ажилласан.

**Хугацаа:** 2022 оны 08 дугаар сарын 09-ний өдрөөс 08 дугаар сарын 13-ны өдөр

**Явсан маршрутын зураглал:**

Улаанбаатар-Завхан-Улаанбаатар

# Импортын тайлан



## 2021 оны импорт, борлуулалт /тэрбум төгрөг/, 2021 он




2021 онд нийт **835,4 тэрбум төгрөгийн импорт, 732,9 тэрбум (87.7%) төгрөгийн борлуулалт** хийсэн байна.

## 2021 онд нийт хамгийн их импорт, борлуулалт хийсэн 10 байгууллага




| | Монософарм Трейд ХХК | Монгол Эм Импекс Концерн ХХК | Азифарма ХХК | Энто ХХК | Алтан заан ХХК | Сетунари ХХК | Омбол ХХК | ВэллБий ХХК | Мөнхийн тун ХХК | Цомбо ХХК |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Импортлосон дүн | 151,777,8 | 106,982,2 | 85,220,34 | 68,910,23 | 43,526,04 | 34,565,69 | 21,934,27 | 17,491,67 | 24,356,21 | 14,640,56 |
| Борлуулсан дүн | 140,375,0 | 87,467,64 | 68,629,18 | 52,642,49 | 49,994,74 | 30,667,91 | 18,300,36 | 15,816,69 | 14,777,01 | 14,299,98 |

■ **Импортлосон дүн** ■ **Борлуулсан дүн**

2021 онд Эм, Өнчин эм, Эмийн бүртгэлийн дээж, Эмнэлгийн хэрэгсэл, Протез, Оношлуур, Оношлуур бүртгэлгүй, Оношлуурын бүртгэлийн дээж, Урвалж, Сайдын тушаал, Төрийн хяналтан дор нэвтрүүлэх бараа, Стандарт бодисын импорт хийсэн хамгийн их дүнтэй 10 эм ханган байгууллагаар гаргасан. Үүнд:

# Хангамж, хүртээмжийн үнэлгээний чиглэлээр

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

## Уналт, татлтын эсрэг эм

- 2021 онд 7 улсын 8 үйлдвэрлэгчээс олон улсын нэршлээр 8, худалдааны нэршлээр 10 уналт таталтын эсрэг эмийг импортлосон.
- Уналт таталтын эсрэг эмийн хангамжийн талаар ЭМДЕГ, ЭМЯ, ЦЕГ-ын ХТТГ, ханган нийлүүлэх байгууллага болон холбоод зэрэг талуудтай 12 удаагийн уулзалт зохион байгуулж, хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны талаар мэдээлэл өгч, тулгамдсан асуудлыг хэлэлцсэн.
- Холбоодоос ирсэн хүсэлтийн дагуу нийт 47 нэрийн эмийг ХЭЗ-ийн хурлаар хэлэлцүүлж, ЭМС-ын тушаалаар импортлох нөхцлийг бүрдүүлсэн.

## Өнчин эм

- 60 нэрийн эм
- 35 ЭМБ
- 2021 он, 2022 оны эхний хагас жил хэрэглээний тайланд үнэлгээ хийсэн;
- 2022 оны эхний хагас жилийн байдлаар 5 улсын 14 үйлдвэрлэгчээс 15 олон улсын нэршлээр, 27 худалдааны нэртэй өнчин эмийг эрүүл мэндийн сайдын тушаалаар импортлосон.
- Өнчин эмийн үйлдвэрлэгчийн үнийн өөрчлөлт (-31.3%)-(193.8%), Эрүүл мэндийн байгууллагуудын худалдан авалтын үнийн өөрчлөлт (-58%)-(122%) байна.
- Үнэлгээг ДЗХ-аар хэлэлцүүлсэн.

## Төлбөрийг төр хариуцах эм

- 14 бүлэг өвчний 87 нэрийн эм
- 38 ЭМБ
- 2021 он, 2022 оны эхний хагас жил хэрэглээний тайланд үнэлгээ хийсэн;
- Дотоодын 2 эмийн үйлдвэр 5 нэрийн эм үйлдвэрлэж байна.
- ТТХЭ-ийн үйлдвэрлэгчийн үнийн өөрчлөлт (-52.2%)-(66.1%), Эрүүл мэндийн байгууллагуудын худалдан авалтын үнийн өөрчлөлт (-28%)-(299%) байна.
- 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 44 нэрийн эмийг 14 улсаас импортолсон байна.
- Үнэлгээг ДЗХ-аар хэлэлцүүлсэн.



# 3. Эм, эмнэлгийн хэрэгслийн үнийн зохицуулалт, өртөг үр дүнгийн тооцоо судалгааны чиглэлээр

# Үнийн мэдээний сан, цахимжилт

## 41 нэрийн эм

Өнчин эмийн хэлцлийн үнэ, 2019-2022

## 67 нэрийн эм

Төлбөрийг төр хариуцах эмийн хэлцлийн үнэ, 2020-2022

## 552 нэрийн эм

ЗШЭ (том хүн, хүүхэд)-ийн хэлцлийн үнэ, 2019-2022

## 632 нэрийн эм

ЗШЭ (том хүн, хүүхэд)-ийн бөөний болон жижиглэнгийн үнэ, 2022

## 420 нэрийн эм

Төрийн өмчит эмнэлгүүдийн худалдан авсан эмийн үнэ, 2019-2021

## Цахим тогтолцоо

| Зөвшөөрсөн/тоо х... | Импортлосон/тоо х... | Импортын дүн | Импортын үндс... | Импортолсон огноо |
|---|---|---|---|---|
| = | = | = | = | = |
| 216 | | | | |
| 216 | | | | |
| 288 | | | | |

Licemed програмд харагдах байдал

- Гаалийн мэдүүлгийн систем
- Цахим төлбөрийн систем

ebarimt НӨАТУС

Татварын ерөнхий газар, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын **“Хамтран ажиллах гэрээ”** байгуулсан.

| № | Системээс харах мэдээлэл |
|---|---|
| 1 | Он, сар, өдөр |
| 2 | Эмийн баркод |
| 3 | Баркодын нэр |
| 4 | Тоо хэмжээ |
| 5 | Хэмжих нэгж |
| 6 | Нэгжийн үнэ |
| 7 | Нийт үнэ |
| 8 | Аймаг, дүүрэг |

### Үнийн ил тод байдал

Цахим тогтолцоог бүрдүүлэх замаар бүх эмийн үнийн ил тод байдлыг хангах

# Үнийн судалгаа



## Үнэд нөлөөлөх гол хүчин зүйл

| № | Үнэ өсөлтийн шалтгаан | | 2019-2020 онд нэмэгдсэн хувь | 2020-2021 онд нэмэгдсэн хувь | 2021-2022 онд нэмэгдсэн хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | Инфляци % | | -49% | 92% | 121% |
| 2 | Валют /Жилийн дундаж/ | *Америк доллар* | 6% | 1% | 7% |
| | | *Евро* | 8% | 5% | -3% |
| | | *ОХУ-ын рубль* | -5% | -1% | 17% |
| | | *БНХАУ-ын юань* | 6% | 8% | 5% |
| | | *БНСУ-ын вон* | 4% | 4% | -4% |
| 3 | Тээврийн зардал | *Инчеон-УБ /агаар кг/* | 4% | 60% | -16% |
| | | *Эрээн-УБ /газар м3/* | 4% | 199% | 5% |
| 4 | Түүхий эдийн үнийн өсөлт | *Парацетамол (кг)* | 14% | 34% | 11% |
| 5 | Сав баглаа боодлын үнийн өсөлт | *PVC (кг)* | 4% | 10% | 42% |

## Эмийн үнэ бүрдэл:




**Нийт нэмэгдэл:**
Импорт 80.5%-123.5%
Дотоод 60%-100%

Хэлцлийн үнэ → Тээвэр, даатгал 5%-8% → Гааль, НӨАТ 15.5% → Ханган нийлүүлэх байгууллагын нэмэгдэл 15%-45% → Борлуулалтын НӨАТ 10% → Эмийн сангийн нэмэгдэл 25%-35% → Борлуулалтын НӨАТ 10%

1. Дотоодын үйлдвэрийн эмийн хувьд нэмэгдэл 41%-98%
2. Импортын эмийн хувьд гарал үүслийн улсаас хамааран 60%-238%-ийн нэмэгдэлтэй байна.

## ЗШЭ-ийн үйлдвэрлэгчийн үнэ өсөлт

Сүүлийн 3 жилийн хугацаанд /2020-2022 онд/:

**Тасралтгүй импорт хийгдсэн 553 нэрийн зайлшгүй шаардлагатай эмийн** үйлдвэрлэгчийн үнэ 2020-2022 онд 254 хүртэлх хувиар нэмэгдсэн байна.




Засгийн газрын хуралдаанд танилцуулах эмийн нөөц, тасалдал, валют гүйлгээ, тээвэрлэлт, үнийн өсөлтийн талаар 7 удаагийн мэдээлэл, танилцуулга бэлтгэж ЭЗХЯ-нд хүргүүлсэн.



# 4. КОВИД 19-ийн цар тахал болон гамшгийн үеийн бэлэн байдлыг хангах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ

# Тогтмол хийгддэг ажил





- ЭМБ-ын нөөц, тасалдал
- Зах зээлийн нөөцийн мэдээ, тасалдал
- Тээвэрлэлт
- Гүйлгээний хүсэлт
- Байнгын хороо, УОК, Засгийн газрын хуралд танилцуулах ЭМЯ, ЭЭХХЗГ-ын танилцуулга
- Хэвлэлийн мэдээ

# Хэрэгжүүлсэн ажлууд



## Нөөцийн улсын хэмжээний нэгдсэн мэдээлэл

- ✓ Эрүүл мэндийн байгууллага, ханган нийлүүлэх байгууллагын нөөцийн мэдээллийг 7 хоног бүр нэгтгэн гаргаж, КОВИД-19 шалтгаант хэвтэн эмчлүүлэгчдийн тоо, ПГУ лабораторийн хүчин чадал, улсын 1 өдрийн хэрэгцээнд үндэслэн нөөц хүрэлцэх хоногийг 52 удаа тооцоолж, нөөцийн байдалд хяналт тавьж ажилласан.

## Тээвэрлэлт

- ✓ Төмөр зам болон авто замаар- 120 ханган нийлүүлэх байгууллагын 531 вагон/чингэлгийн ачааны мэдээллийг ЗТХЯ, ГХЯ, УБТЗ-д хүргүүлж, татан авсан.
- ✓ Тусгай үүргийн нислэгээр болон ердийн нислэгээр ЭМЯ, ЗТХЯ болон МИАТ ТӨХК-тай хамтран 97 тонн тасалдах эрсдэлтэй эм, эмнэлгийн хэрэгслийг татан авах ажлыг зохион байгуулсан.

## Тасалдах эрсдэлтэй эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж

- ✓ Гадаадаас шууд худалдан авах 136 нэрийн эмийн хэрэгцээг тооцоолсон (уналт таталт, хавдрын эсрэг эм, төлбөрийг төр хариуцах, өнчин, өндөр өртөгт эм г.м).

## Санхүү, төлбөр тооцоо

Гадаад гүйлгээний хязгаарлалт:

- ✓ Гадаад гүйлгээний хүсэлтийг ханган нийлүүлэх байгууллагуудаас 7 хоног бүр авч, нэн шаардлагатай, тасалдал үүссэн байдлаар нь эрэмбэлэн Монгол банкинд 20 удаагийн албан бичгээр хүргүүлэн ажилласан. Нийт 85 байгууллагын 123.5 тэрбум төгрөгийн гүйлгээний хүсэлтийг Монгол банканд хүргүүлсэн байна.

Репо зээл:

- ✓ 35 ХНБ-ын 47,4 тэрбум төгрөгийн Репо зээлийн хүсэлтийг ЭМЯ, Монгол банканд хүргүүлж, Монгол банктай 2 удаагийн уулзалт зохион байгуулсан. Монгол банкаас эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж оношлуур, түүхий эд, тоног төхөөрөмжийн нөөцийг дотоодод бүрдүүлэх үйл ажиллагаанд зориулан 10 тэрбум төгрөгийг арилжааны банкуудад дамжуулан ХНБ-уудад олгосон.

Эрүүл мэндийн байгууллагуудын өр төлбөр:

- ✓ 44 ханган нийлүүлэх байгууллага, үйлдвэрлэгчийн авлагын мэдээллийг гаргаж, 53.5 тэрбум төгрөгийн өр төлбөрийг барагдуулах ажлыг ЭМЯ-тай хамтран зохион байгуулсан.



# 5. Бусад

# Хэрэгжүүлсэн ажлууд

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

## Эрт илрүүлэг

23 аж ахуйн нэгжийн импортолдог нийт 52 нэрийн урвалж, оношлуур, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн мэдээг нийт 36 удаа гаргаж, ЭМЯ-нд хүргүүлсэн. ЭМЯ, ЭМДЕГ, НЭМГ, ХНБ, ЭМБ-тай танхимын болон цахимын нийт 15 удаагийн уулзалт зохион байгуулсан.

## 11-11 гомдол, санал

2022.04.18-2022.12.12-ны хооронд ирүүлсэн эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц, тасалдал, үнэтэй холбоотой нийт 105 санал, гомдолд шуурхай хариу арга хэмжээ авсан.

## Европоос татан авах эмийн танилцуулга

Эрүүл мэндийн сайд Копенгагенд айлчлахтай холбогдуулан Европоос татан авах шаардлагатай хорт хавдрын эсрэг 16 нэрийн, хүүхдийн хорт хавдрын эсрэг 6 нэрийн, уналт таталтын эсрэг 11 нэрийн, тасалдах өндөр эрсдэлтэй 6 нэрийн эмийн хэрэгцээ, үнэ, шаардлагатай 7,6 тэрбум төсвийг тооцоолж, Монгол, Англи хэл дээр каталоги бэлтгэн ЭМЯ-нд хүргүүлсэн.







## Эмийн эрсдлийн үнэлгээ

Монгол улсад бүртгэлтэй нийт 4248 эмэнд эмнэлзүйн ач холбогдол, импортлогчийн тоо болон Монгол улсад бүртгэгдсэн байдлаар нь эрсдэлийн үнэлгээ хийхэд 387 нэрийн эмийн нөөцийн байдалд хяналт тавих шаардлагатай гэсэн судалгааны үр дүн гарсан.

# 2023 онд хэрэгжүүлэх томоохон ажил



- Эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж, хүртээмжийн хяналтын цахим мэдээллийн сантай болох нөхцөлийг бүрдүүлэх. */үнэ, худалдан авалт, нөөц/*
- Эмийн үнийн цахим систем дэх мэдээллийг стандартжуулах. */эмийн нэр, нэгж үнэ, хэмжих нэгж/*
- Эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүний үнийн тандалт, зохицуулалт хийх журмын төслийг боловсруулна.
- Ерөнхий гэрээгээр худалдан авах эм, эмнэлгийн хэрэгслийн нэр төрлийг нэмэгдүүлнэ.
- Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн нөөцийн бэлэн байдлыг хангах зохицуулалт хийнэ.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

# Анхаарал хандуулсанд баярлалаа